

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН “МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР-3”
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах албан хаагч	Биелэлт
1	2	3	4	5	6
Нэг. Монгол бичгийн хэрэглээний орчныг бүрэн бүрдүүлэх					
1.1	Байгууллагын нэр хаягжилтыг монгол бичгээр бичиж байршуулах	Байгууллагын нэр хаягжилтыг монгол бичгээр бичиж байршуулсан байна	I улирал	Мэдээлэл технологийн ажилтан	2021 оноос байгууллагын нэр хаяг, өрөө тасалгаа, албан хаагчийн нэр хаяг зэргийг Монгол бичгээр хослуулан байршуулсан. 2024 онд 24/7 улсын бүртгэлийн үйлчилгээний самбарыг Монгол бичгээр хослуулан байршуулсан.
1.2	Албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийн түвшинг тогтоох	Албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийн түвшинг тогтоосон байна	III улирал	Хяналтын улсын байцаагч	Тус хэлтсийн 26 албан хаагчдаас Монгол бичгийн унших, ярих, бичих чадварын түвшин тогтоох судалгаа авахад унших чадвар 70.1%, бичих чадвар 52.8% байна.
1.3	Монгол бичгийн мэдлэг чадварыг нэмэгдүүлэх, сургалт, сурталчилгааны ажлыг хариуцах алба хаагчийг томилон ажиллуулах	Хариуцах албан хаагч томилогдсон байна	I-IV улирал	Сургалтын баг	Монгол бичгийн мэдлэг чадварыг нэмэгдүүлэх, сургалт, сурталчилгааны ажлыг хариуцахаар хяналтын улсын байцаагч, Мэдээлэл технологийн ажилтан, бичиг хэргийн ажилтан нарыг томилон ажиллуулсан.
1.4	Хэвлэл мэдээлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг крилл, монгол бичгээр зэрэгцүүлэх, нийтэлж эхлэх	Хэвлэл мэдээлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг крилл, монгол бичгээр зэрэгцүүлж нийтлэх	I-IV улирал	Мэдээлэл технологийн ажилтан	Тус хэлтэс улсын бүртгэлийн чиглэлээр З контент/ богино бичлэг/-ийг хийсэн бөгөөд бичигэн текстийг Монгол бичгээр хослуулан бичсэн.
1.5.	Монгол бичгийн хичээлийг анхан,	Зохион байгуулсан сургалт, хамрагдсан албан хаагчдын	I-IV улирал	Сургалтын баг	Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн Монгол хэлний багш

	дунд шатны сургалтад хамруулах /Гаднаас сургагч багш урьж албан хаагчдад танхимиын болон цахим сургалтыг үе шаттай зохион байгуулах/	тоо			Т.Цэвэгсүрэнг урин Монгол бичгийн анхан шатны сургалтыг зохион байгуулж хэлтсийн 15 албан хаагч танхим, 11 албан хаагч цахимаар сургалтад хамрагдсан.
1.6	УБЕГ болон нэгж салбарууд тогтмол монгол бичгийн холбогдолтой /"Зөв бичигтэн болон цэвэр сайхан бичигтэн шалгаруулах уралдаан", "Тунгаамал" эх хэлний уралдаан, "Үндэсний бичгээр хэн хурдан унших вэ" уншлагын уралдаан гэх мэт/ уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулах	Уралдаан тэмцээн зохион байгуулсан байна.	IV улирал	Сургалтын баг	УБЕГ-аас зохион байгуулсан Монгол бичгийн эсээ бичлэгийн уралдаанд Иххэт сумын улсын бүртгэгч Д.Мөнхцэцэг, архивч Ц.Наранчимэг нар оролцож эсээг Үндэсний бичиг болон кирилл бичигт хөрвүүлж хүргүүлсэн.
Хоёр. Албан хэргийг крилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлж, бэлтгэл хангах зорилтын хүрээнд					
2.1.	Монгол бичгийн албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглаж буй суурин /зөөврийн компьютер/ компьютерт криллээс монгол бичигт хөрвүүлэх программ нэгдсэн журмаар суулгаж, ашиглалт хэрэглээг уриалах	Алба хаагчдын монгол бичигт хөрвүүлэх программ нэгдсэн журмаар суулгах	I-IV улирал	Бичиг хэргийн ажилтан	Монгол бичгийн албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглаж буй кириллээс монгол бичигт хөрвүүлэх программыг бичиг хэргийн ажилтны суурин компьютерт суулгаж, албан хэрэгцээнд хэрэглэн ашиглаж байна.

ТАЙЛАН БИЧСЭН: ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

Э.УРАНБИЛЭГ

ТАЙЛАН ХЯНАСАН: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТЭГШЖАРГАЛ

